



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 20 өдөр

Дугаар A/630.

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11/02 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 128 дугаар тогтоолыг тус, тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2019 оны ажлаар баруун бүсийн шилдэг сумдаар шалгарсан 4 сумын шагналд зарцуулах 20 000 000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Тус шагналд зарцуулах 20 000 000 төгрөг /Хорин сая/-ийг аймгийн 2020 төсөвт батлагдсан Засаг даргын зарцуулах төсвийн арга хэмжээний санхүүжилтээс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ДУГЭРЖАВ



Zax A/630 Ch

02 02724

Аймгийн Засаг даргын 2020 оны 10 дугаар  
сарын 20-ны өдрийн А/630 дугаар  
захирамжийн хавсралт



2019 ОНЫ АЖЛААР БАРУУН БҮСИЙН ШИЛДЭГ  
СУМДААР ШАЛГАРСАН СУМЫН ШАГНАЛ

дд	Аймаг, сумын нэр	Шагналын дүн /мянган төгрөг/
1	Баян-Өлгий аймгийн Толбо сум	5000.0
2	Увс аймгийн Өмнөговь сум	5000.0
3	Говь-Алтай аймгийн Эрдэнэ сум	5000.0
4	Завхан аймгийн Тосонцэнгэл сум	5000.0
5	Нийт дүн	20000.0

-оОо-